

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мерен сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khivsgui@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/198
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ЧУЛУУНХҮҮ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,345,247.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 1,054,498.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үлдэгдэл 290,748.8 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 36,044.0 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс, 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгч, 2 алдааг залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 87.0 хувьтай дүгнэсэн байна.

67120108

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	393,579,325.23	612,350,011.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	221,753,259.52	108,294,331.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	221,753,259.52	108,294,331.13
3121	Төгрөг	221,753,259.52	108,294,331.13
31211	Төрийн сангийн харилцах	221,753,259.52	108,294,331.13
33	АВЛАГА	19,960,058.00	290,748,808.95
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,960,058.00	290,748,808.95
35	БАРАА МАТЕРИАЛ	151,866,007.71	213,306,871.44
351	Түүхий эд материал	49,784,799.22	74,017,082.83
35130	Эм боох материал	49,784,799.22	74,017,082.83
354	Хангамжийн материал	102,081,208.49	139,289,788.61
35410	Бичиг хэргийн материал	2,916,535.00	4,856,110.00
35420	Аж ахуйн материал	76,512,609.52	100,999,406.74
35430	Сэлбэг хэрэгсэл	2,160,000.00	2,160,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,063,125.00	14,176,050.00
35460	Хүнсний материал	6,364,554.65	8,033,837.55
35470	Бусад хангамжийн материал	9,064,384.32	9,064,384.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	306,786,877.04	477,291,131.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	306,786,877.04	477,291,131.45
392	Биет хөрөнгө	277,096,877.12	447,711,131.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	216,825,849.00	216,825,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(123,706,424.60)	(136,945,318.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,736,000.00	266,328,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,830,061.45)	(48,412,761.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	398,863,840.39	424,119,367.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(264,372,454.29)	(287,747,532.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,076,800.43	43,290,950.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,496,672.36)	(29,747,422.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,709,179.00	6,709,179.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,709,179.00)	(6,709,179.00)
393	Биет бус хөрөнгө	29,689,999.92	29,579,999.88
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(495,000.08)	(605,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,360,000.00	29,360,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	700,366,202.27	1,089,641,142.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,894,540.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,894,540.10
413	Өглөг	0.00	10,894,540.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	10,894,540.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	700,366,202.27	1,078,746,602.87
51	Засгийн газрын хувь оролцоо	700,366,202.27	1,078,746,602.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	269,328,439.00	269,328,439.00
51101	Өмч: - төрийн	269,328,439.00	269,328,439.00
512	Хуримтлагдсан үр дүн	330,337,545.47	708,717,946.07
51210	Өмнөх үеийн үр дүн	330,337,545.47	330,337,545.47
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	378,380,400.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,700,217.80	100,700,217.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	700,366,202.27	1,089,641,142.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,011,302,387.42	1,712,791,156.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,366,401.84	321,079,030.27
120	Нийтлэг татварын бус орлого	87,366,401.84	321,079,030.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,366,401.84	321,079,030.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	46,861,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,366,401.84	274,218,030.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	923,935,985.58	1,391,712,126.42
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,464,000.00	30,158,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,464,000.00	30,158,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	904,296,985.58	1,361,553,226.42
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	904,296,985.58	1,361,553,226.42
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	950,031,692.86	1,332,010,755.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	950,031,692.86	1,332,010,755.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950,031,692.86	1,280,883,701.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,640,642.64	872,869,992.20
210101	Үндсэн цалин	427,275,011.24	528,850,836.63
210102	Нэмэгдэл	102,409,199.79	253,729,800.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,221,989.76	24,066,000.00
210104	Урамшуулал	54,939,097.70	66,223,354.67
210105	Гэрээт ажлын хөлс	2,795,344.15	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,750,194.96	100,621,950.66
210201	Тэтгэврийн даатгал	51,064,769.57	69,498,595.77
210202	Тэтгэмжийн даатгал	6,219,612.37	8,770,663.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,764,825.86	4,766,798.07
210204	Ажилгүйдлийн даатгал	963,653.38	3,554,227.71
210205	Эрүүл мэндийн даатгал	9,737,333.78	14,031,665.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,274,874.70	20,334,970.17
210301	Гэрэл, цахилгаан	4,514,000.00	4,925,845.17
210302	Түлш, халаалт	15,410,874.70	13,939,125.00
210303	Цэвэр, бохир ус	1,350,000.00	1,470,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,506,795.00	70,197,772.18
210401	Бичиг хэрэг	3,806,935.00	2,355,225.00
210402	Тээвэр, шатахуун	44,614,860.00	39,291,035.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,420,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	938,000.00	978,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,507,000.00	23,067,288.18
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,086,224.00
2105	Нормативт зардал	81,404,843.84	85,309,807.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,657,721.84	67,150,990.36
210502	Хоол, хүнс	13,747,122.00	18,158,817.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,876,500.00	6,416,500.00
210604	Урсгал засвар	5,876,500.00	6,416,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,034,000.00	6,303,400.00
210702	Дотоод албан томилолт	2,034,000.00	6,303,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,571,738.00	18,261,953.00

/төгрөгөөр/

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,794,100.00	16,380,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	221,070.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,848.00	385,548.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	58,720.00	88,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,972,103.72	100,567,355.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,272,700.00	14,681,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,699,403.72	85,885,805.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	51,127,054.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	50,622,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	50,622,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	505,054.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	505,054.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	61,270,694.56	380,780,400.76
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,039,000.00	2,400,000.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,950,000.00	2,400,000.16
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	89,000.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,039,000.00)	(2,400,000.16)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	59,231,694.56	378,380,400.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	903,975,927.58	1,167,784,375.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	46,861,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	46,861,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	46,861,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	46,861,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	903,975,927.58	1,120,923,375.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,464,000.00	30,158,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,464,000.00	30,158,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	884,336,927.58	1,090,764,475.47
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	884,336,927.58	1,090,764,475.47
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	841,756,416.30	1,263,803,303.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	841,756,416.30	1,263,803,303.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	841,756,416.30	1,212,676,249.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,485,613.34	862,729,897.20
210101	Үндсэн цалин	343,385,384.58	509,473,665.67
210102	Нэмэгдэл	201,151,789.67	262,966,876.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,050,439.76	24,066,000.00
210104	Урамшуулал	40,599,507.70	66,223,354.67
210105	Гэрээт ажлын хөлс	2,298,491.63	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,750,194.96	99,867,505.56
210201	Тэтгэврийн даатгал	51,064,769.57	69,498,595.77
210202	Тэтгэмжийн даатгал	6,219,611.37	8,770,763.76

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,764,825.86	4,766,797.07
210204	Ажилгүйдлийн даатгал	963,653.38	3,554,227.71
210205	Эрүүл мэндийн даатгал	9,737,334.78	13,277,121.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,464,000.00	27,075,845.17
210301	Гэрэл, цахилгаан	4,514,000.00	4,925,845.17
210302	Түлш, халаалт	13,600,000.00	20,680,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,350,000.00	1,470,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,953,820.00	63,089,885.00
210401	Бичиг хэрэг	3,482,660.00	4,561,300.00
210402	Тээвэр, шатахуун	38,069,860.00	41,663,085.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,420,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,874,000.00	5,819,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,887,300.00	8,626,000.00
2105	Нормативт зардал	59,139,950.00	92,039,763.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,939,100.00	68,011,663.10
210502	Хоол, хүнс	12,695,850.00	19,828,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,505,000.00	4,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,858,800.00	28,867,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,982,300.00	2,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	2,350,000.00
210604	Урсгал засвар	5,876,500.00	23,767,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,034,000.00	6,303,400.00
210702	Дотоод албан томилолт	2,034,000.00	6,303,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,661,738.00	18,261,953.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,884,100.00	16,380,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	221,070.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,848.00	385,548.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	58,720.00	88,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,408,300.00	14,440,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,408,300.00	14,440,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	51,127,054.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	50,622,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	50,622,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	505,054.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	62,219,511.28	(96,018,928.39)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	13,439,900.00	17,440,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,439,900.00	17,440,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,439,900.00	17,440,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,439,900.00	17,440,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,439,900.00)	(17,440,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	48,779,611.28	(113,458,928.39)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	172,973,648.24	221,753,259.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	221,753,259.52	108,294,331.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	271,105,850.91	641,134,507.71
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	59,231,694.56	59,231,694.56
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	330,337,545.47	700,366,202.27
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	330,337,545.47	700,366,202.27
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	330,337,545.47	700,366,202.27
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	378,380,400.60	378,380,400.60
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	708,717,946.07	1,078,746,602.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,350,455,400.00	1,251,084,403.86	92.64	99,370,996.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,350,455,400.00	1,251,084,403.86	92.64	99,370,996.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,270,455,400.00	1,200,462,403.86	94.49	69,992,996.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	863,206,200.00	862,729,897.20	99.94	476,302.80
210101	Үндсэн цалин	529,675,200.00	509,473,665.67	96.19	20,201,534.33
210102	Нэмэгдэл	263,560,000.00	262,966,876.86	99.77	593,123.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,351,500.00	24,066,000.00	180.25	(10,714,500.00)
210104	Урамшуулал	56,619,500.00	66,223,354.67	116.96	(9,603,854.67)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,900,700.00	99,867,505.56	92.56	8,033,194.44
210201	Тэтгэврийн даатгал	73,372,500.00	69,498,595.77	94.72	3,873,904.23
210202	Тэтгэмжийн даатгал	8,632,100.00	8,770,763.76	101.61	(138,663.76)
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,316,000.00	4,766,797.07	110.44	(450,797.07)
210204	Ажилгүйдлийн даатгал	4,316,000.00	3,554,227.71	82.35	761,772.29
210205	Эрүүл мэндийн даатгал	17,264,100.00	13,277,121.25	76.91	3,986,978.75
2104	Хангамж, бараа материалын зардал	91,767,800.00	63,089,885.00	68.75	28,677,915.00
210401	Бичиг хэрэг	5,128,600.00	4,561,300.00	88.94	567,300.00
210402	Тээвэр, шатахуун	62,136,700.00	41,663,085.00	67.05	20,473,615.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,721,100.00	2,420,000.00	65.03	1,301,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,031,400.00	5,819,500.00	96.49	211,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,750,000.00	8,626,000.00	58.48	6,124,000.00
2105	Нормативт зардал	103,203,600.00	92,699,763.10	89.82	10,503,836.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,422,600.00	68,671,663.10	110.01	(6,249,063.10)
210502	Хоол, хүнс	28,781,000.00	19,828,100.00	68.89	8,952,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,000,000.00	4,200,000.00	35.00	7,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,190,700.00	43,069,500.00	99.72	121,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,329,400.00	19,250,000.00	105.02	(920,600.00)
210602	Тавилга	3,333,600.00	280,000.00	8.40	3,053,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,444,500.00	2,350,000.00	52.87	2,094,500.00
210604	Урсгал засвар	17,083,200.00	21,189,500.00	124.04	(4,106,300.00)

2107	Томилолт, зочны зардал	6,500,000.00	6,303,400.00	96.98	196,600.00
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	6,303,400.00	96.98	196,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,013,400.00	18,261,953.00	45.64	21,751,447.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,000,000.00	16,380,400.00	46.80	18,619,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	100.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	200,925.00	50.23	199,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	385,548.00	96.39	14,452.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	55,000.00	22.00	195,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	861,400.00	0.00	0.00	861,400.00
210807	Газрын төлбөр	180,000.00	88,080.00	48.93	91,920.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,770,000.00	0.00	0.00	1,770,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,673,000.00	14,440,500.00	98.42	232,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,673,000.00	14,440,500.00	98.42	232,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,000,000.00	50,622,000.00	63.28	29,378,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,000,000.00	50,622,000.00	63.28	29,378,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	50,622,000.00	63.28	29,378,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,350,455,400.00	1,137,625,475.47	84.24	212,829,924.53
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,026,742,000.00	1,054,498,475.47	102.70	(27,756,475.47)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,026,742,000.00	1,054,498,475.47	102.70	(27,756,475.47)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	321,713,400.00	83,127,000.00	25.84	238,586,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000,000.00	83,127,000.00	103.91	(3,127,000.00)
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	241,713,400.00	0.00	0.00	241,713,400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	221,753,259.52		(221,753,259.52)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	108,294,331.13		(108,294,331.13)

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,158,900.00	29,653,845.17	98.32	505,054.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,158,900.00	29,653,845.17	98.32	505,054.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,158,900.00	29,653,845.17	98.32	505,054.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,158,900.00	27,075,845.17	99.00	83,054.83
210301	Гэрэл, цахилгаан	4,778,900.00	4,925,845.17	103.07	(146,945.17)
210302	Түлш, халаалт	20,680,000.00	20,680,000.00	100.00	-
210303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	1,470,000.00	86.47	230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,578,000.00	85.93	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,578,000.00	85.93	422,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,158,900.00	29,653,845.17	98.32	505,054.83
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,158,900.00	29,653,845.17	98.32	505,054.83
320001	Орон нутгийн төсвөөс	30,158,900.00	29,653,845.17	98.32	505,054.83

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,044.0 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс, 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгч, 2 алдааг залруулсан.

3.1 Залруулсан алдаа

- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих дүнг мөнгөн гүйлгээний тайлан дээр 20,990.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төсвийн гүйцэтгэлийн эх үүсвэрийг зөв болгож залруулга хийсэн.
- Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн болон зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байсныг аудитын явцад нөхөж бэлтгэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 15,054.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 146.5 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

3.2 Албан шаардлага

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 12,467.7 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн, хугацаа дууссан 1,961.0 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай

нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 7,968.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан "Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1 заалтад "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;" мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

2024 онд 1,361,654.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 36,367.7 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын 3.1 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

4. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн өмчийн байрны урсгал засвар хийх зориулалттай зардлаас автомашины засвартай холбоотой 2,578.0 мянган төгрөгийн зардал гаргасан, ажиллагсдад томилолтын нөхөн төлбөр олгохдоо цалингийн бүлэгт хамааралтай 175,0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг хасч олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

5. Бараа материалын бүртгэлийн асуудал

Илрүүлэлт:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах үүднээс жилийн эцэст шилжүүлсэн биетээр байхгүй 2,372.1 мянган төгрөгийн шатахууныг орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 заалт “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх

Өгсөн зөвлөмж:

Цаашид бараа, ажил үйлчилгээний урьдчилж шилжүүлсэн мөнгийг урьдчилгаа дансаар бүртгэж байх.

6. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 33, зарлагын 20 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 47 шийдвэр, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, санхүүгийн тайлан, хандив тусламжийн орлогын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

7. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй.	1	-	1	-			1	-		
ЭМДС-аас авсан санхүүжилтийн дүнг мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй тайлагнасан.	1	20,990.0			1	20,990.0	1	20,990.0		
Дүн	2	20,990.0	1	-	1	20,990.0	1	20,990.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн "Зөчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан байна.	1	7,968.0					1	7,968.0
Биетээр оршин байхгүй шатахууныг бараа материалд бүртгэсэн.	1	2,372.0					1	2,372.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас автомашины сэлбэг худалдаж авч, зарцуулсан, зардлын эдийн загийн ангилал зөрчсөн	1	2,753.0					1	2,753.0
Дүн	4	13,093.0					4	13,093.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас давсан.	1	-			1	-		
Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-
Бараа материалын үлдэгдэлд хугацаа дууссан эмийн үлдэгдэлтэй байна.	1	1,961.0			1	1,961.0		
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй	1	-					1	-
Дүн	6	1,961.0			2	1,961.0	4	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 50/АЭЭТ-0469/

Мөрөн сум

ХВА-2025/100/НА-СТ-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 12,467,600 (арван хоёр сая дөрвөн зуун жаран долоон мянга зургаан зуун) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Чулуунхүү, нягтлан бодогч Б.Бямбадорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724070482



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 49/19270469/

Мөрөн сум

УАН-2025/100/НА-УВ-ТНЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарлагдаагүй, эмчилгээнд хэрэглэх шаардлага гараагүй, хугацаа дууссан зэрэг шалтгаанаар тус байгууллагын бараа материалын дансны үлдэгдэлд 1,960,998 (нэг сая есөн зуун жаран мянга есөн зуун ерэн найман) төгрөгийн өмнөх оноос шилжиж ирсэн, бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй эм бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалахгүй байх, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, бараа материалын үлдэгдлийн эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг тууштай мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Чулуунхүү, нягтлан бодогч Б.Бямбадорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724070184